

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 дугаар сарын 13

Дугаар 82

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 2023 оны газар зохион
байгуулалтын төлөвлөгөөний биелэлт дүгнэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван тавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2023 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

НЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛУУД

№	Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжилт	Хувь
0	1	2	3
1.1. Хууль эрх зүйн чиглэлээр хийх ажлууд			
1.	Газрын ерөнхий хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын төлбөрийн хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хууль, Кадастрын тухай хууль зэрэг 5 хуульд өөрчлөлт оруулах, батлуулах асуудлаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагад уламжлах	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хуралдаанаар Газрын тухай багц хуулийн төслийг хэлэлцүүлж Улсын Их Хуралд мэдүүлэхээр шийдвэрлэлээ. Газрын багц хуульд Газрын ерөнхий хууль, Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Кадастрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулиуд багтаж байна.</p> <p>Газрын багц хууль батлагдсанаар Монгол Улсыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан шинээр олгох газрыг төлөвлөх, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн бүх шатны баримт бичигт салбарын яам, агентлаг болон иргэд, олон нийтээс санал авах, газрын нэгдсэн төлөвлөлт, бүртгэлээр дамжуулж салбар хоорондын уялдааг хангах, төрөөс олгосон газар өмчлөх эрх болон газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрхийг хамгаалж, газар олгох, бүртгэх, гэрчилгээ олгох үйл ажиллагааг цахим системээр ил тод, түргэн шуурхай байгуулах, иргэн, хуулийн этгээд газрын цахим биржээр дамжуулан газар авах, арилжаалах болон Монгол Улсын иргэн өмчилж авсан газраа Монгол Улсын хуулийн этгээдэд газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх, худалдаа үйлчилгээний зориулалтаар ашиглах, төрийн өмчийн газрыг Иргэний хуулийн суурь эрхийн зохицуулалттай нийцүүлэх, иргэн хуулийн этгээдэд тодорхой зориулалт, хугацаагаар шилжүүлэх, гэрээгээр ашиглуулах боломж бүрдэж, нийтийн зориулалттай орон сууц болон олон өмчлөгчтэй барилгын доорх газрын эрхийг өмчлөгч нарт нь дундын мэдлийн газрын эрхийг олгох боломж бүрдэх юм.</p> <p>2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 14:00 цагт Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо Соёлын ордны хурлын зааланд Геодези, зураг зүйн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Газрын багц хуулиар хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p>	100

		Хэлэлцүүлэгт нийт 420 орчим иргэн оролцсон.	
2.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолын холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар санал өгч оролцоно.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Менежмент төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн шейф файл дээр суурин судалгаа хийж, -Ундны эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс орсон 1052 - Усан сан, ундны усны эрүүл ахуйн хориглолтын бүсэд өртсөн 433 иргэн, хуулийн этгээдийн нэгж талбарыг байршил өөрчлөх, хүчингүй болгох, газар чөлөөлөх ажлын судалгааг шинэчлэн гаргаж, 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 15/627 тоот албан бичгээр Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.	100
3.	Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын дагуу газрын үнэлгээний итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг шинэчлэх, дүгнэх, хэрэгжилтийг зохион байгуулах	Газрын кадастрын мэдээллийн системд суурилсан Газрын төлбөр, татварын системд Газрын татвар, төлбөрийг газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжийг ашиглан Газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэл үүсгэх, улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэн татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулах, хөрөнгийн бүртгэлийг 100 хувь үүсгэн ажиллахаар холбогдох хэлтэс, албад руу хандан ажиллаж байна. 2022 онд 30028 татвар төлөгчөөр бүртгүүлсэн. 2023 онд 32808 татвар төлөгчөөр бүргүүлсэн байна. Дүүргийн Засаг даргын захирамжтай гэрээний 35182 нэгж талбараас 32817 нэгж талбарт нэхэмжлэл үүсгэж, газрын төлбөрийн ногдуулалт 93,3%, Тусгай хамгаалалттай газар ашиглах 243 нэгж талбараас 232 нэгж талбарт нэхэмжлэл үүсгэн, гэрээний ногдуулалт 95,5 хувьтай байна. E-gazar, E-Mongolia, E-Barimt зэрэг аппликейшнүүдийг ашиглан газрын төлбөрөө хэрхэн төлөх gazar.ub.gov.mn болон egazar.gov.mn сайтуудыг ашиглан газартай холбоотой бүх төрлийн мэдээллийг авах талаар зөвлөгөө өгч цахим үйлчилгээг ажилдаа нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн газрын төлбөрийн ногдуулалт, төлөлттэй холбоотой дундын вэб мэдээллийн санд иргэн хуулийн этгээдийн баяжилт хийв. Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэн ажиллах талаар 2023 оны 2-р улиралд дүүргийн Засаг даргын 22 удаагийн захирамжинд хамаарах 379 иргэн, 8 хуулийн этгээдийн цахим гэрчилгээний улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгаврыг үүсгэсэн.	100
4.	Тусгай хамгаалалттай газар нутаг /Богдхан уул/, түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх асуудлын хүрээнд холбогдох төрийн болон орон нутгийн захиргааны	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дах хэсэгт заасныг үндэслэн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Баянзүрхийн товчоо, Хүрхрээ орчмын 93 га газар нутгийн Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын бүсээс гаргах, Хонхор нуурын орчимд 93 га газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авах саналыг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн	100

	байгууллагуудтай хамтран ажиллах, санал хүргүүлэх	хурлаар хэлэлцүүлж, 2022 оны 53 дугаартай тогтоолыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2023 оны 2/04 тоо албан бичгээр хүргүүлэн ажилласан.	
1.2 Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил			
5.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг хангах	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/126 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавьж ажилласан бөгөөд төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хангах, захиалагчийн хяналт тавих, хамтарч ажиллах чиглэлээр 6 удаагийн ажлын хэсэг байгуулан, үр дүнтэй ажилласан. Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах үүднээс төслийг эрдэмтэн, судлаачдын багаар хэлэлцүүлж, саналуудыг тусган ажилласан.	58
6.	Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, холбогдох шийдвэрийг гаргуулан бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллах	Дүүргийн 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 11, 29, 33 дугаар хороодод тус тус 1 байршилд Рашааны зориулалтаар, 20, 33 дугаар хороодод тус бүр 2, нийт 6 байршилд орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч намрын нэгдсэн хурлаар дахин хэлэлцүүлэхээр хойшлуулсан.	70
7.	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод болгох, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Газрын бирж”-ийн цахим систем / www.mle.mn / -ийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	Газрын эрх шилжсэн 89 нэгж талбарын газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын биржийн www.mle.mn цахим системд бүртгэн ажиллалаа.	100
8.	Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулахтай холбогдуулан бэлтгэл ажлыг зохион байгуулах	Хаягжилтын цахим систем нэвтэрүүлсэнтэй холбогдуулан газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй хаяггүй болон шинээр төлөвлөлтөнд орсон нэгж талбарыг хороо, гудамжны нэршил, хаягийг нэгтгэж байна. Мөн Газар Зохион байгуулалт, Геодези Зураг Зүйн газрын хаягжилтын ажилд, сургалт авч байна.	100

		2022 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд хэвтрүүлэх тухай” журмын өөрчлөлт оруулснаар 5.5-д нийслэлийн хэмжээнд нийслэлийн Газар зохион байгуулалтын алба энэхүү журмын 5.2.1-д өмчлөх, зэмших, ашиглах ээрх үүссэн газарт хаяг олгоно гэж заасны дагуу Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албанаас нийслэлийн хэмжээнд хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг орон зайн өгөгдөл, мэдээллийн геопорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байгаа болно.	
9.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, мод үржүүлгийн зориулалтаар эзэмших газрын байршил, хэмжээг тогтоох.	2023 оны 05 дугаар сарын 18-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо Тарвагатайн аманд байрлах “Инчеоны мөрөөдлийн төгөл”-д 50 ширхэг, 5 сарын 20-ны өдөр 11 дугаар хороо, Улиастайн гүүрны урд 60 ширхэг, 10 дугаар сарын 12-ны өдөр 33 дугаар хороо, Шар хоолойн гүүр хэсэгт 50 ширхэг, нийт 160 ширхэг модыг албан хаагч нар хамтран тарьсан.	100
1.3 Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил			
10.	Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын зөрчлийг арилгаж, газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Нийслэлийн Байгаль орчны газарт нийслэлийн Засаг дарга, Газар Зохион Байгуулалт, Геодези, Зураг Зүйн газар, ТЕГ-ийн дарга нарын баталсан №А/1144. А/157. А/157 тоот журмын дагуу ажиллахаар албаны 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 15/136 албан бичиг явуулсан. 2023 онд 32808 татвар төлөгчөөр бүргүүлсэн байна. Дүүргийн Засаг даргын захирамжтай гэрээний 35182 нэгж талбараас 32817 нэгж талбарт нэхэмжлэл үүсгэж, газрын төлбөрийн ногдуулалт 93,3%, Тусгай хамгаалалттай газар ашиглах 243 нэгж талбараас 232 нэгж талбарт нэхэмжлэл үүсгэн, гэрээний ногдуулалт 95,5 хувьтай байна.	100
11.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолоор батлагдсан нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	Иргэдээс 11310005 дугаарын нийслэлийн шуурхай утсанд болон цаг үеийн байдлаар ирсэн нийт 26 дуудлагаар ирүүлсэн газрын зөрчлийг тухайн өдрийн жижүүр газар дээр нь очиж, хугацаатай мэдэгдэх хуудас хүргүүлж ажиллаж байна. Мөн 10, 11, 14, 20, 26, 33 дугаар хорооны нутаг дэвсгэрт орц гарц хааж, мухар гудамж үүсгэсэн нийт 8565 метр хашааг чөлөөлж, зөрчлийг арилгуулсан.	100
12.	Орон сууцны хороолол дундах автомашины гараашуудыг буулган газрыг чөлөөлж, чөлөөлөгдсөн газарт олон нийтэд зориулсан ногоон байгууламж, тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийх боломжийг бүрдүүлэн нийтийн эдэлбэр газраар бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах	Орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчилд: Нийслэлийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн Газрын зөрчил арилгах тухай А/321 дүгээр захирамжийн хүрээнд манай алба 11 байршилд 184 ширхэг тоосгон болон төмөр гарааш буулган газрын зөрчил арилгахаас 7 байршилд 67 тоосгон болон төмөр гарааш албадан буулгаж газар чөлөөлөх ажил хийгдээд байна. 100 %	100

		Тус дүүргийн 14, 15, 18 дугаар хороодын 4 байршлын 117 тоосгон гарааш нь НЗД-ын захирамжтай болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй тул газрын зөрчил арилгаж, газар чөлөөлөх ажил хийгдэх боломжгүй болж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас чиглэл авахаар хүсэлт хүргүүлсэн бөгөөд газар чөлөөлтийн ажил хийгдэхээргүй чиглэл ирвэл 100 %-тай болно.	
13.	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд барилгын норм дүрэм зөрчиж газар эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэрийг дүүргийн Засаг даргын захирамжаар цуцлах, тухайн байршилд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан тохижилт, ногоон байгууламж, биеийн тамирын талбайг байгуулах ажлыг зохион байгуулах	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Хар усан тохой хэсэгт байрлах ундны усны эрүүл ахуйн хязгаарлалтын бүсэд газар эзэмших эрхтэй 166 иргэн хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг үндэслэн хүчингүй болгохоор Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа хийгдэж байна. Мөн инженерийн шугам сүлжээний шугамын хамгаалалтын бүсэд өртсөн 12 нэгж талбарын хэлбэрийг өөрчилж, зөрчлийг арилгуулсан.	70
Газар зохион байгуулалтын чиглэлээр:			
14.	Налайх дүүрэг, Баянзүрх дүүргийн хилийн цэсийн маргааныг холбогдох дээд шатны байгууллагуудаар шийдвэрлүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах	Хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх ажлын хэсгийн хурлаар 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхор нуурын нутагт 45 нэгж талбар, 20 дугаар хороо, Энгэр шанд, Майхан уул, Их амуудад нийт 292 нэгж талбарыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан бөгөөд Нийслэлийн Засаг даргын дэргэдэх ажлыг хэсэг байгуулагдан эцсийн шийдвэр гараагүй байна.	100
15.	Газрыг улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох асуудлыг Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах, холбогдох байгууллагад саналыг хүргүүлэх	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Баянзүрх хайрханы орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийг өөрчлөх тухай саналыг ДИТХ-д хүргүүлсэн бөгөөд ДИТХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлхээр хүлээгдэж байна. Мөн 11 дүгээр хороо, Рашаан, 29 дүгээр хороо, Сэлбэ Дондогдуламын рашаан, 20, 33 дугаар хороо, Шар хоолой хэсэгт Ангиртай бүс, Хундай, Дээндий ам, 33 дугаар хороо, Бага шар хоолой хэсэгт Уламжлалт мал аж ахуй хөгжүүлэх зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, хамгаалалтын бүсийн хил заагийг тогтоох тухай саналыг ДИТХ-д хүргүүлэн Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч намрын нэгдсэн хурлаар дахин хэлэлцүүлэхээр хойшлуулсан.	100
16.	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор орон нутгийн тусгай	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Баянзүрх хайрханы орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийг өөрчлөх тухай саналыг ДИТХ-д хүргүүлсэн бөгөөд ДИТХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлхээр хүлээгдэж	100

	хамгаалалтад авсан газар нутаг түүний хамгаалалтын бүс, хил заагийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх, хяналт тавих	байна. Мөн 11 дүгээр хороо, Рашаан, 29 дүгээр хороо, Сэлбэ Дондогдуламын рашаан, 20, 33 дугаар хороо, Шар хоолой хэсэгт Ангиртай бүс, Хундай, Дээндий ам, 33 дугаар хороо, Бага шар хоолой хэсэгт Уламжлалт мал аж ахуй хөгжүүлэх зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, хамгаалалтын бүсийн хил заагийг тогтоох тухай саналыг ДИТХ-д хүргүүлэн Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч намрын нэгдсэн хурлаар дахин хэлэлцүүлэхээр хойшлуулсан.	
17.	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нь хүчингүй болж, төрийн мэдэлд шилжсэн газруудыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн нээлттэй дуудлага худалдааны зарчмаар газар эзэмших, ашиглах эрх олгох ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нь хүчингүй болж, төрийн мэдэлд шилжсэн нэгж талбар байхгүй болно.	100
18.	Иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрөлгүйгээр ашиглаж буй илүү талбайн нь бусдын газар эзэмшилтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихөөргүй, нийслэлийн газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үе шатны төсөл, газар ашиглалтын бүсчлэлтэй уялдаж байгаа тохиолдолд ашиглаж буй илүү талбайн хэмжээг нэмж эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар шийдвэрлэх, болон газрын давхардлыг арилгах ажлыг зохион байгуулах.	Илүү талбай ашиглаж байгаа нийт 36 иргэн, хуулийн этгээдийн 29 байршилд 2490 метр хашаа, хайс чөлөөлж газрын зөрчил арилгасан. Мөн 20 дугаар хороонд эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн 3 нэгж талбарт, 33 дугаар хороонд 9 нэгж талбар бүхий илүү талбайтай газарт мэдэгдэл хүргүүлэн, газар чөлөөлсөн.	100
19.	Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар хийгдэх улсын болон орон нутгийн чанартай авто зам, явган хүний зам, инженерийн шугам сүлжээний трасс болон нийгмийн хангамжийн барилга, байгууламж, сургууль, цэцэрлэгийн барилга барих газрын байршлын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн газрыг нөхөх олговортойгоор	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдын хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ний 11/33 тогтоолын 24.2.4 заалтын дагуу Баянзүрх дүүргийн 9, 23 дугаар хороо гачууртын авто замаас шар хадны автобусны эцсийн зогсоол хүртэлх 4.27 км авто замын барилга баригдах ажлын нөлөөлөлд зөвшөөрөлтэй 114 нэгж талбар, зөвшөөрөлгүй 6 нэгж талбар нийт 120 нэгж талбар өртсөн. Үүнээс: 1.Нөхөх олговрын зардлыг бууруулахын тулд 58 нэгж талбарыг нөлөөллөөс гаргаж, үлдсэн 56 нэгж талбараас 46 нэгж талбарт 2.6 тэрбум төгрөг олгосон. Зөвшилцөөгүй үлдсэн 10 нэгж талбараас зөөврийн ус түгээх 446 дугаар худгийг УСУГазар болон Баянзүрх дүүргийн 35 дугаар хороотой хамтран байршил	100

	чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах, нөхөх олговрын хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар хийгдэх улсын болон орон нутгийн чанартай авто зам, явган хүний зам, инженерийн шугам сүлжээний трасс болон нийгмийн хангамжийн барилга, байгууламж, сургууль, цэцэрлэгийн барилга барих газрын байршлын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн газрыг нөхөх олговортойгоор чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах, нөхөх олговрын хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах	шилжүүлэхээр албан бичиг хүргүүлж, 4 иргэнтэй зөвшилцөх ажил хийгдэж байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны 11/33 дугаар тогтоолын 4.1.22-д Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Гачууртын авто замын төгсгөлөөс зүүн тийш 4,7 км үргэлжлэх шинээр барих авто замын ажлын нөлөөлөлд иргэдийн зөвшөөрөлгүй сунгасан хашаанд Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 57.4-т заасны дагуу чөлөөлөх арга хэмжээ авч, шийдвэрлэсэн.	
20.	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамрагдсан газар нутгийн судалгааг гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал бэлтгэн, холбогдох шийдвэрийг гаргуулах	2023 онд 380 газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааг цахимаар баталгаажуулсан байгаа бөгөөд цаашид цахим системээр баталгаажуулан ажиллаж байна.	100
21.	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах	2023 онд Газрын мониторингийн цахим системд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааг баталгаажуулахаар ирүүлсэн тайлан, дүгнэлтийг судалж, 380 нэгж талбарын тайланг баталгаажуулсан. Мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан эсэх болон тайланг үнэн бодитой тайлагнаж байгаа тал дээр мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.	100
22.	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах, тайланг хүргүүлэх	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр дэх бэлчээрийн фото мониторингийн 2 цэг нь 20 дугаар хорооны Улиастай ам, Гүнжийн хоолойд байрлалтай байдаг бөгөөд манай албаны нутаг дэвсгэрт одоогоор фото мониторингийн цэг байхгүй байна.	100
Дөрөв. Газар өмчлөлийн чиглэлээр хийгдэх ажил			
23.	Газар өмчилсөн иргэдийн шийдвэрийн төсөл бэлтгэх ажлын хэсгийн хурлаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, кадастрын зурагт өөрчлөлт оруулах асуудлыг тухай бүрт нь хэлэлцэж шийдвэрлэх	Тус дүүргийн газраа өмчлүүлэх хүсэлтэй нийт 156 иргэний хүсэлтийг хүлээн авч, “Газар өмчлөлийн шийдвэрийн төсөл бэлтгэх ажлын хэсгийн хурал”-р хэлэлцүүлээд байна. Нийслэлийн Засаг даргын 16 удаагийн захирамжаар 131 иргэнд 7.6 га талбай бүхий газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн.	30

24.	Улаанбаатар хотын ногоон бүс буюу зуслангийн амнуудад газар эзэмшиж байгаа иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах	Улаанбаатар хотын ногоон бүс буюу зуслангийн амнуудад газар эзэмшиж байгаа иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Бага ам, Туул, Гачуурт төвийн хэсэг, Гялалзах, Дээд шар хоолой хэсэгт нийт 15 иргэнд 0.9 га талбай бүхий газрыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар өмчлүүлсэн.	100
25.	Газар өмчлөх иргэдийн санал, хүсэлтийг цахим системээр хүлээн авах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэх	Дүүргийн хэмжээнд 2023 онд нийт 391 иргэнд гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн болно. Мөн 2024 оны газар өмчлөхөөр нийт 716 иргэний саналыг бүртгээд байна.	100
Тав. Газрын кадастрын чиглэлээр хийгдэх ажил			
26.	Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Газар эзэмших ашиглах эрхийг хянан шийдвэрлэх зөвлөлийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ, байршилд өөрчлөлт оруулах, дүйцүүлэн олгох, хэлбэр өөрчлөх, хугацааг сунгах, газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох асуудлуудыг тухай бүрт нь хэлэлцэж шийдвэрлэх	2023 онд Баянзүрх дүүргийн Засаг даргын 43 удаагийн захирамжаар 1255 ИААНБ-ын хүсэлт шийдвэрлэсэн. - Газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа сунгах-10 удаагийн захимжаар 56 ИААНБ - Газар эзэмших, ашиглах эрх шилжүүлэх -15 удаагийн захимжаар 502 ИААНБ - Газар эзэмшиж ашиглаж буй газрын зориулалт өөрчлөх-1 удаагийн захимжаар 2 ИААНБ - Газар эзэмшиж ашиглаж буй газрын талбайн хэмжээ өөрчлөх-21 удаагийн захимжаар 60 ИААНБ - Газар эзэмших эрх дуусгавар болгох тухай -1 удаагийн захимжаар 4 иргэн аж ахуйн нэгжийн хүсэлтийг шийдвэрлэсэн байна.	100
27.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны даргын тушаалаар байгуулагдсан Газрын кадастрын мэдээллийн санд хяналт тавих ажлын хэсгийн хуралаар иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын байршлын кадастрын зургийг шинээр бүртгэх, талбайн хэмжээ, хэлбэр өөрчлөх, устгах, сэргээх, устгагдсан байршилд шинээр нэгж талбар бүртгэхтэй холбоотой асуудлуудыг тухай бүр хэлэлцэж шийдвэрлэх.	Тайлант хугацаанд нийт 572 иргэн, хуулийн этгээдэд үйлчилж, 403 нэгж талбарыг газрын кадастрын мэдээллийн санд оруулж, өөрчлөлтийг хийж, бүртгэсэн. Үүнээс -Кадастрын зургийн нэр өөрчилсөн 312, - хуваалт 18, - хаяг сольсон 21, - нэгтгэсэн 4, - шинээр байшин оруулах 65 -байшин устгах 12 хүсэлтүүдийг зураг бүртгэж, хуулийн этгээдийн хүсэлтийг шийдвэрлэн ажиллалаа.	100

28.	<p>Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган газар ашиглалтыг сайжруулах, авто зам болон явган хүний зам талбайг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах болон тохижилтын ажил гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын зөрчил арилгах, орчны аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Дүүргийн Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилт Хашаа арга хэмжээний хүрээнд - 17 байршилд 17 хашаа буулгахаас 14 байршилд 125 метр хашаа, хайс чөлөөлсөн.</p> <p>- 14 байршилд 184 гарааш чөлөөлөх судалгаа гаргаж 7 байршилд 67 тоосгон болон төмөр гарааш албадан буулгаж газар чөлөөлөх ажил хийгдээд байна.</p> <p>Тус дүүргийн 14, 15, 18 дугаар хороодын 4 байршлын 117 тоосгон гарааш нь НЗД-ын захирамжтай болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй тул газрын зөрчил арилгаж, газар чөлөөлөх ажил хийгдэх боломжгүй болж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас чиглэл авахаар хүсэлт хүргүүлсэн болно.</p>	70
29.	<p>Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, авто болон явган хүний зам хааж байрлуулсан хашаа, хайс, объектуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлж зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах</p>	<p>1. Гэр хорооллын мухар гудамж, зуслангийн орц, гарц, хаасан нийт 10 байршилд газрын зөрчлийн судалгааг гаргаж, хугацаатай мэдэгдэл хүргүүлэн, зөрчлийг бүрэн арилгасан. 100%-тай биелсэн. Үүнд: Мөн 10, 11, 14, 20, 26, 33 дугаар хорооны нутаг дэвсгэрт орц гарц хааж, мухар гудамж үүсгэсэн нийт 8565 метр хашааг чөлөөлж, зөрчлийг арилгуулсан.</p> <p>2. Орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчилд: Нийслэлийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн Газрын зөрчил арилгах тухай А/321 дүгээр захирамжийн хүрээнд 11 байршилд 184 ширхэг тоосгон болон төмөр гарааш буулган газрын зөрчил арилгахаас 7 байршилд 67 тоосгон болон төмөр гарааш албадан буулгаж газар чөлөөлөх ажил хийгдээд байна. 36.4 % Харин 4 байршлын 117 тоосгон гарааш нь НЗД-ын захирамжтай болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй тул газрын зөрчил арилгаж, газар чөлөөлөх ажил хийгдэх боломжгүй болж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас чиглэл авахаар хүсэлт хүргүүлсэн бөгөөд газар чөлөөлтийн ажил хийгдэхээргүй чиглэл ирвэл 100 %-тай болно. Мөн Нийслэлийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, авто замын түгжрэлийг бууруулах, явган хүний зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбайг нэмэгдүүлэх, зорилгоор хууль, журам зөрчсөн, стандартын бус хашаа, хайс барьсан газруудын зөрчлийг арилгах, зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай А/394 дүгээр захирамжийн дагуу 17 байршлийн 1085метр хашаа, хайс чөлөөлж газрын зөрчил арилгасан. Биелэлт 100%</p>	100

30.	Дүүргийн нутаг дэвсгэрт инженерийн шугам сүлжээ, түүний хамгаалалтын бүс дэх холбогдох судалгааг нэгтгэн гаргах, хангагч байгууллагатай хамтарч ажиллах.	Дүүргийн нутаг дэвсгэрт инженерийн шугам сүлжээ, түүний хамгаалалтын бүс дэх холбогдох судалгааг нэгтгэн гаргасан бөгөөд, хангагч байгууллагатай хамтарч ажиллаж байна.	100
31.	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний хүрээнд Газрын тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг зөрчсөн төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалангийн талбайн зориулалтаар эзэмшиж ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн газарт судалгаа хийж зөрчилтэй нэгж талбаруудыг цуцалж төсөл хэрэгжүүлэх байгууллагад эзэмшүүлэн эргэлтийн талбайн ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хоро, Хонхор хэсэгт газар эзэмшигч нь өөрийн эзэмшил газраас хэтрүүлэн 18.2 га талбайд зөвшөөрөлгүй атар газар хагалж, газар тариалангийн үйл ажиллагаа явуулсан зөрчлийг илрүүлэн зөрчлийг арилгуулан захиргааны арга хэмжээ авах тухай хүсэлтийг Экологийн цагдаагийн албанд хүргүүлсэн.	100
1.6 Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил			
32.	Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.	Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ны А/1007 дугаар захирамжаар Геодезийн байнгын цэг тэмдэгтийн тооллого явуулах ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий Климакс реферэнс ХХК-иар дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд цэг тэмдэгтийн тооллого хийсэн. Тооллогоор 221 ширхэг геодезийн байнгын цэг тэмдэгт байгаа бөгөөд 170 ширхэг геодезийн байнгын цэг тэмдэгт устаж 51 цэг тэмдэгт бүрэн байгаа судалгаа гарсан. 2023 оны Геодезийн байнгын цэг тэмдэгтийн тооллого явуулах ажил хийгдэж байна.	100
33.	Иргэн, хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем, гар утасны аппликейшнд хөгжүүлэлт хийж газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч хувь хүн, хуулийн этгээдүүд өөрийн газартай холбоотой төрийн үйлчилгээг газрын	Иргэд, хуулийн этгээдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй ажиллах зорилгоор Төрийн үйлчилгээг сайжруулан Egazar аппликейшн, операторын болон масс мессеж үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн Төрийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид зориулсан албаны цахим үйлчилгээтэй холбоотой гарын авлага, зурагт хуудас бэлтгэн ажиллалаа. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагад танилцуулга материал тарааж, www.egazar.gov.mn сайт, egazar аппликейшныг хэрхэн ашиглах, дүүргийн газар	100

	удирдлагын цахим системийг ашиглаж хүсэлт гаргах, хамааралтай мэдээ мэдээллийг зохих журмын дагуу түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх.	зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх, цахимаар хэрхэн газар холбоотой үйлчилгээ авах, газрын төлбөрийг хэрхэн цахимаар хялбар төлж болох зэрэг зөвлөмжүүдийг тус дүүргийн хуулийн этгээдүүд болон төрийн байгууллагуудад нийт 210 иргэнд ажил зохион байгуулсан ажилласан. Албаны ажлын байр дээр “Egaza.gov.mn” аппликейшныг хэрхэн ашиглах, газартай холбоотой үйлчилгээг авах талаар зааварчилгаа хийж, иргэн өөрөө шууд сайт руу нэвтрэн кадастрын зураг, гэрчилгээ, лавлагааг хэвлэн авч байна.	
34.	Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын орон зайн мэдээллийг бүрдүүлж, газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд оруулах.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, 6000 га талбай бүхий Баянзүрх хайрханыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай саналыг дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлхээр бэлтгэж байна.	30
35.	Баянзүрх дүүрэг дэх газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажил болон газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах.	Газар зохион байгуулалт, Геодези зураг зүйн газрын даргын 2019 оны А/290 дүгээр тушаалаар батлагдсан Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн дүрмийн дагуу нийслэлийн Засаг даргын 2023 оны Н/03 дугаар захирамжаар Газар зүйн нэрийн салбар зөвлөл шинэчлэгдэн байгуулсан. Дээрх салбар зөвлөл хуралдаан 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурал хойшилсон, дараагийн хурал зарлагдаагүй байна. Газар зүйн салбар зөвлөлийн хурлаар төлөвлөгөөг боловсруулан батлуулахаар хүлээгдэж байна	57
1.7 Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэлээр хийх ажлууд			
36.	Газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмшигч, ашиглагч нарын бүртгэлийн алдаагүй, үндсэн нэгж талбарын газрын төлбөрийн ноогдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх ажлыг зохион байгуулах	Газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэл үүсгэх, улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэн татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулах, хөрөнгийн бүртгэлийг 100 хувь үүсгэн ажиллахаар холбогдох хэлтэс, албад руу хандан ажиллаж байна. 2022 онд 30028 татвар төлөгчөөр бүртгүүлсэн. 2023 онд 32808 татвар төлөгчөөр бүргүүлсэн байна. Дүүргийн Засаг даргын захирамжтай гэрээний 35182 нэгж талбараас 32817 нэгж талбарт нэхэмжлэл үүсгэж, газрын төлбөрийн ногдуулалт 93,3%, Тусгай хамгаалалттай газар ашиглах 243 нэгж талбараас 232 нэгж талбарт нэхэмжлэл үүсгэн, гэрээний ногдуулалт 95,5 хувьтай байна.	94

ХОЁР. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТОО, ХЭМЖЭЭ

2.1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээг тогтоох							
д/д	Хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Иргэдийн тоо	Хэрэгжилт	Хувь
0	1	2	3	4	5	6	7
1.	2	Их Дарь-эх	Гэр бүлийн хэрэгцээ	0.81	13	9	69.2
2.	8	Улаанхуаран, Эрдэнэтолгой, Холбоо толгойн гудамж		0.88	13	3	23
3.	9	Шархад		0.53	8	1	12.5
4.	10	Витсамо, Улаанхуаран, Амгалан, Төмөр зам, Хангамжийн гудамж		6.4	108	-	-
5.	11	Товчоо, Туул, Эмийн ургамал, Хөлийн гол, Дэнж, Баянбулаг, Баянзүрх, Усан сан, Ургах наран		31.4	508	365	71.8
6.		Сүүл даваа, Нам даваа, Дунд даваа, Налайхын пост		88.4	1459	444	30.4
7.		Булгачин, Хонхор нуур		93.48	1558	261	16.7
8.	12	Сармисны хонхор, Жанжин, Чулуут, Төмөр зам		1.22	20	1	5
9.	13	Дүүрэг		0.3	8	5	62.5
10.	17	Ногоочин, Эрдэнэтолгой, Эмнэлэг		0.78	14		
11.	19	Цайз, Жаргалант, Дэнж		1.32	21		
12.	20	Гялалзах, Сүүл даваа		21.74	368	1488	20.8
13.		Энгэр шанд		46.8	781		
14.		Майхан уулын ард		81.47	1355		
15.		Хар усан тохой		16.6	272		
16.		Бага ам		1.8	31		
17.		Могойт дэнж, Бага хуандай, Дээндий, Өлийн даваа		37.36	587		
18.		Их хуандай ам		100.7	1679		
19.		Могойт дэнж, Хар хошуу, Арцат, Цэмбэл		123.72	2060		
20.	21	Ганцын худгийн задгай /Хорих ангийн хамгаалалтын бүсэд орсон айл/		57.5	1150	361	28.5
21.		Бага дарь-Эх		5.74	95		

22.	22	Өлгийн гудамж		0.05	1		
23.	23	Улиастай, Сургууль		0.7	34	7	20.5
24.	24	Цахлай, Овоот Жаргалант, Хоршооллын гудамж, Газарчин		5.62	107		
25.	25	Олзвойн гудамж		0.05	1		
26.	27	Жамсран уулын ар, өвөр гудамж		8.17	133	7	5.2
27.	28	Хужирбулан		2.8	48	19	39.5
28.	29	Сэлбэ гудамж		0.7	10	1	10
29.	30	Цэргийн хотхон гудамж		1.11	18		
30.	31	Монелийн гудамж		3.8	76		
31.	32	Баруун алтан өлгий, Зүүн алтан өлгий, Бунханы		1.94	32		
32.	33	Их ам, Шар хоолой		163.3	2573	849	33
33.		Төвийн хэсэг, Их ам, Гачуурмаа		5.32	84	1349	18.9
34.		Булагийн ам,		39.9	602		
35.		Шивэртийн ам, Дунд төгөл		60.75	921		
36.		Бага шар хоолой,		23.3	350		
37.		Гээпилийн ам, Дархитын ам		48.7	733		
38.		Баяндөхөм, Гүнжийн хоолой		130.97	1871		
39.	34	Ээж хайрхан, Цагаан давааны ам, Шар хад, Тоосгоны ар, Үнэгтийн ам, Давсны булаг		14.52	305		
40.	35	Баатархайрханы 2 дугаар хэсэг		39.5	650	571	19.5
41.		Майхантын ам		9.27	151		
42.		Шарын ам		25.64	402		
43.		Баянголын ам		38.1	606		
44.		Хиймтийн ам		13.75	225		
45.		Богдын даваа, Цагаан давааны ам		28.35	455		
46.		Хожуултын ам		26.89	434		
47.	37	Сармисны хонхор, Жанжин, Чулууны овоо АОС		0.26	8		
48.	38	Улаанхуарангийн гудамж		0.07	1		
Нийт				1412.5	22939	5846	25.35

2.2. Өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ

д/д	Хороо	Газрын байршил	Иргэдийн тоо	Газрын хэмжээ /га/	Хэрэгжилт	Хувь
0	1	2	3	4	6	7
1.	10	Хангамж, Шархад, Витсамо, Улаанхуаран, Амгалан, Эмнэлэг, Холбоотолгойн гудамж	49	1.23	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 15 иргэний 0.86 га өмчлүүлсэн	30.6
2.	11	Дэнж, Эмийн ургамал, Товчоо, Хонхор, Хөх тэнгэр, Булгачин, Баянбулаг, Замчин, Ногоон зоорь, Усан сан, Төмөрзам, Баянзүрх, Хөлийн гол	155	9.29	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 46 иргэний 2.75 га өмчлүүлсэн	29.6
3.	12	Жанжин, Төмөр замын гудамж	9	0.41	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 5 иргэний 0.3 га өмчлүүлсэн	55.5
4.	13	Дүүргийн гудамж	1	0.038	Хүсэлт ирүүлээгүй байна.	-
5.	14	Консулын гудамж	3	0.056	Хүсэлт ирүүлээгүй байна.	-
6.	20	Туул ферм, Гялалзах, Туул, Шархоолой, Улаан эрэгийн гудамж	52	3.22	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 15 иргэний 0.94 га өмчлүүлсэн	28.8
7.	23	Сургууль, Улиастай, Баатархайрханы гудамж	23	1.11	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 4 иргэний 0.2 га өмчлүүлсэн	17.3
8.	28	Хужирбулангийн гудамж	93	5.35	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 28 иргэний 1.6 га өмчлүүлсэн	30.1
9.	37	Чулуутын, Жанжины гудамж	5	0.27	Хүсэлт ирүүлээгүй байна.	-
10.	42	Консулын гудамж	1	0.042	Хүсэлт ирүүлээгүй байна.	-
11.	2	Их Дарь-Эхийн гудамж	14	0.73	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 5 иргэнд өмчлүүлсэн.	35.7
12.	8	Улаанхуаран, Эрдэнэтолгой, Холбоотолгойн гудамж	6	0.215	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 2 иргэнд өмчлүүлсэн.	33.3
13.	9	Шархад, Эмнэлэг, Ээж хайрханы гудамж	19	0.754	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 18 иргэнд өмчлүүлсэн.	94.7
14.	17	Эрдэнэтолгой, Эмнэлэг, Сүрлэн, Шархад, Холбоотолгойн гудамж	17	0.842	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 5 иргэнд өмчлүүлсэн	29.4
15.	19	Цайз, Хоршоолол, Цэргийн хотхон, Жаргалант, Дэнжийн гудамж	41	2.383	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 9 иргэнд өмчлүүлсэн	21.9
16.	21	Дарь Эх, Жамсран уулын өвөр, Жамсран уулын ар, Цэргийн хотхон	16	0.866	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 10 иргэнд өмчлүүлсэн	62.5

17.	22	Баруун, Зүүн Алтан-Өлгийн гудамж	1	0.046	Хүсэлт ирүүлээгүй байна.	-
18.	24	Цахлай, Хоршоолол, Жаргалант, Газарчин, Овоот Цэргийн хотхон, Жаргалантын гудамж	34	1.538	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 18 иргэнд өмчлүүлсэн	52.9
19.	27	Жамсран уулын ар, өвөр, Монел, Дунд Дарь эхийн гудамж	45	2.677	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 17 иргэнд өмчлүүлсэн	37.7
20.	29	Сэлбэ	9	0.442	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 2 иргэнд өмчлүүлсэн	22.2
21.	30	Цэргийн хотхон, Сансар хотхон, Од Монел	23	1.328	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 9 иргэнд өмчлүүлсэн	39.1
22.	31	Монел, Монел уул	38	2.006	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 32 иргэнд өмчлүүлсэн	84.2
23.	32	Баруун, Зүүн Алтан-Өлгийн гудамж	15	0.755	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 7 иргэнд өмчлүүлсэн	46.6
24.	33	Шархоолой, Төв, Дархит Хадтай, Баяндөхөм гудамж	44	2.789	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 4 иргэнд өмчлүүлсэн	9.09
25.	34	Ээжхайрхан, Шархад, Тоосгоны арын гудамж	58	3.393	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 7 иргэнд өмчлүүлсэн	12.06
26.	35	Баатархайрхан, Улиастайн, Сургуулийн гудамж	49	3.165	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 8 иргэнд өмчлүүлсэн	16.3
27.	38	Эрдэнэтолгойн, Улаанхуарангийн гудамж	2	0.048	Хүсэлт ирүүлээгүй байна.	-
28.	40	Дандар, ЦИС-ийн гудамж	2	0.135	Хүсэлт ирүүлээгүй байна.	-
29.	41	Өлгийн гудамж	1	0.0032	Хүсэлт ирүүлээгүй байна.	-
Нийт			825	45.13		37.5

2.3. Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд

д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хэрэгжилт	Хувь
0	1	2	3	4	5	6
1.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	Сайханы 3 дугаар гудамж	Нийгмийн дэд бүтэц	0.1	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна.	100
2.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	Наран 9 дүгээр гудамж	Нийгмийн дэд бүтэц	0.045	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100

3.	Баянзүрх хороо дүүргийн 9 дүгээр хороо	Шархадны эцэс	Авто бусны эцсийн буудал	0.15	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
4.	Баянзүрх хороо дүүргийн 10 дугаар хороо	Цагдаа хотхоны хойно	Хорооны байр	0.1	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
5.	Баянзүрх хороо дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор нуур	Сургууль	1.0	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
6.	Баянзүрх хороо дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор нуур	Цэцэрлэг	1.0	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
7.	Баянзүрх хороо дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор нуур	Эмнэлэг	1.0	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
8.	Баянзүрх хороо дүүргийн 12 дугаар хороо	Чулуу овоо АОС хороололын урд талд	Тохижилт цэцэрлэгт хүрээлэн	0.1	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
9.	Баянзүрх хороо дүүргийн 17 дугаар хороо	Эрдэнэтолгой 29-716 тоот	Хорооны байр	0.07	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
10.	Баянзүрх хороо дүүргийн 33 дугаар хороо	Шар хоолой ам	Худаг	0.02	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
11.	Баянзүрх хороо дүүргийн 33 дугаар хороо	Шар хоолой ам	Хэсгийн байр	0.12	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
12.	Баянзүрх хороо дүүргийн 20 дугаар хороо	Гялалзах	Хэсгийн байр	0.12	Газар эзэмших эрх олгохоор захирамжийн төсөлд хянагдаж байна	100
